

Эрзурум хот дахь Ил хаант улсын соёлын дурсгал

Цогбадрахын Улаанаа 

Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, ахисан түвшний
хөтөлбөрийн алба, Улаанбаатар, Монгол Улс
✉ ulaanaa@mnuac.edu.mn

Мижиддоржийн Энхбаатар 

Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, ахисан түвшний
хөтөлбөрийн алба, Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Бүгд Найрамдах Турк Улсын Эрзурум хотын түүхийн үнэт дурсгал, соёлын биет өв, эртний урлагийн бүтээлд тооцогдож буй хоёр уран барилга, Хасан цайз Чобандеде гүүрийн тухай авч үзсэн болно. Турк улсын хилийн хотуудын нэг Эрзурум нь торгоны замын чухал бүс болж, Анатолийн зүүн хязгаарт оршиж эртнээс өнөөг хүртэл геополитикийн хувьд ч өндөр ач холбогдолтой хот байсаар иржээ. Хотын төвд Хос баганат сүм/Хатуниез медресе (1285-1290), Якутиез медресе (1310-1311) хэмээн нэрлэгдэх хоёр уран барилга байх нь Ил хаант улсын монголчуудын бүтээн байгуулалтын жишээ бөгөөд судлаачид Эрзурумыг хот болгон хувиргасан уран барилга, түүхийн дурсгал гэж тэмдэглэжээ. Мөн Хасан цайз Чобандеде гүүр зэрэг Ил хаант улсын үед хамаарах буюу Монголчуудын үлдээсэн дурсгалууд энэ хотод бий юм.

Түлхүүр үгс: Эрзурум, Хос баганат сүм, Якутиез медресе, Ил хаант улс, Ил хан

Cultural heritage related to the Mongols of the Ilkhanate in Erzurum

Ulaanaa Tsogbadrakh 

Research and Advanced program department, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ ulaanaa@mnuac.edu.mn

Enkhbaatar Mijiddorj 

Research and Advanced program department, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The city of Erzurum in Türkiye is home to two architectural masterpieces that are considered invaluable cultural and historical heritage and ancient works of art: Hasan Castle and Çobandede Bridge. Located on the eastern edge of Anatolia and on the historical Silk Road, Erzurum is one of Türkiye's current border cities and has long been considered a region of significant geopolitical importance. At the

heart of this city are two important architectural landmarks: the Twin Minaret Madrasa (Hatuniye Madrasa, 1285-1290) and the Yakutiye Madrasa (1310-1311). Scholars have noted that these structures have transformed Erzurum into a city famous for its history and architecture. In addition, landmarks such as Hasan Castle and Çobandede Bridge, dating back to the Ilkhanate period, serve as evidence of the historical heritage left in this city by the Mongols.

Keywords: *Erzurum, Double minaret/Hatuniye, Yakutiye Madrasa, İl Hanlık, İl Han*

Оршил

Монголчууд хүчирхэгжин Эзэнт гүрнийг байгуулж асан тэртээ XIII зууны түүхэнд хамаарах өв соёлын биет дурсгал Ойрхи дорнодын нутагт цөөн биш тохиолдож, шинээр илэрч судалгааны эргэлтэд орж, нийтийн хүртээл болсоор байгаа билээ. Гэвч зарим дурсгалыг таниулах, олны сонорт хүргэх ажил хангалттай биш байгаа нь нутаг алс бөгөөд талбайн судалгаа хийх боломж хомс буйн илрэл юм. Турк улс нь газар зүйн байрлалын хувьд бидний нэрлэж заншсанаар Анатолийн хойг (туркээр: Anadolu; Осман турк *اَنادول* Анатоли)-ийн үржил шимтэй хөрс эртний соёл иргэншлийн эх нутаг болж европ, ази тивийг дамнан оршиж өнөөгийн засаг захиргааны бүтцээр газар нутгийнх нь гурван хувь европ тивд багтаж байна. Харин Эрзурум хот өнөөдөр Зүүн Анатолийн хилийн нэгэн хот бол, эрт үедээ Ром, Визант, Гүрж, Армени, Салтук-Селчукийн улс, Ил хаант улс, Аккоеунлу (Akkoynlu-Цагаан хоньт), Каракоеунлу (Karakoynlu-Хар хоньт), Османы эзэнт гүрэн гээд үе үеийн улс гүрнүүдийн чухал бүс, зүрхэн газруудын нэг нь байжээ. Учир нь Армени, Персийн талаас Турк рүү нэвтрэхдээ дайрч өнгөрөх хилийн хот бөгөөд европ, азийг холбосон торгоны зам ч заавал энэ хотыг дамжин өнгөрнө.

Судалгааны арга зүй

Түүхэн судлалын судалгааны арга зүйд тулгуурлан сурвалж бичгийг үндсэн эх хэрэглэгдэхүүнээ болгохоос гадна, хээрийн шинжилгээний аргын дагуу тухайн дурсгалуудыг биеэр үзэн танилцаж, зураг авч баримтжуулан судалгааны материалуудтай танилцан анализ хийв.

Судалгааны үр дүн

Эрзурум хот нь туркүүд ч монголчууд ч Анатоли руу эхэлж нэвтрэхдээ хүчтэй тэмцэл өрнүүлж эрхшээсэн хот юм. Монголчуудын довтолгоонд хоёр удаа өртсөн бөгөөд эхэлж Чингис хаан Сартуул улсын зүг явуулсан аян дайны үед монголчуудаас зугтаасан Сартуул ноёдын үлдэгдлийг устган Бага азид энх амгалан тогтоох зарлигийг Өгөдэй хаанаас хүлээсэн монгол ноён Байжу эхлээд Иранд ирж Желал ад-дин Султаны цэргийг бут цохиод дараа нь 1242 онд 20 мянган цэрэгтэйгээр Анатолид нэвтрэн Эрзурум хотыг эзэлсэн юм (Анхбаяр, Батхишиг 2016, 15). Монголчууд 1230 он гэхэд Иран болон Азербайжаныг тэр чигт нь эрхшээлдээ оруулсан байсан бөгөөд баруунш чиглэсэн байлдан дагуулал Анатоли руу нэвтэрч Эрзурум хотод алба гувчуур ногдуулан, хараат байдалтай болгосон юм. Байжу ноён 1243 оны хавар Анатолийн төв хэсэг рүү чиглэв. Энэ үед Анатоли

дэх Турк Сельжүкийн султан II Гиас аддин Кеихосров Гүрж, Трабзоны ванлигтай холбоотны харилцаа тогтоон нийт 80 мянган цэрэг хураан 1243 оны хавар Сивас хотын зүг хөдөлжээ. Энэ үед Байжу ноёнд элч заран “манай улс тоймгүй олон хоттой, их цэрэг маань хэмжээлшгүй их билээ. Чи наанаа байж л бай! Би үтэр түргэн давшин ирж цэрэг зэвсгийн хүчээ чамд үзүүлсүү” хэмээсэнд Байжу ноён хариуд нь тайвнаар, “Чи өөртөө дэндүү итгэлтэй өгүүлж байна Гэхдээ ялалт цэргийн хүчээр олддог зүйл бишээ. Юу болохыг гагцхүү мөнх тэнгэр соёрхдог билээ” (Jean-Paul Roux 2001, 301) хэмээн хариулсан байдаг.

II Гиас аддин Кеихосров султаныг Сивас хотноо ирсэн тухай мэдээг хүлээж авсан Байжу ноён 20 мянган цэргээ удирдан тосон хөдлөхөд II Гиас аддин Кеихосров султан хэрхэн тулалдах төлөвлөгөө боловсруулахдаа хүчирхэг цайз бэхлэлттэй, хүнс хангамжийн өргөн нөөцтэй Сивас хотод хориглон байлдахын оронд тосон хөдөлсөн нь түүний гаргасан хамгийн том алдаа болжээ. Тэрээр Сивас хотоос зүүн зүгт 130 орчим км-ийн зайд байх Көседаг (Зураг 1) уулын орчимд монголчуудыг хориглон байлдахаар хуарагнажээ. Көседаг уул нь далайн түвшнээс дээш 2815 метр өндөрт оршино.



Зураг 1. Көседаг уулын тулалдааны дурсгалын өдөр 2018.07.15¹

Уг газар нь эргэн тойрон уулаар хүрээлэгдсэн агт морьдын бэлчээр усаар баялаг нарийн урт хөндий тул амыг нь хааж байлдах нь монголчуудын хувьд оновчтой тактик байв. 1243 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Байжу ноёны магнайн анги Көседаг уулын бэлд давшин орж Сельжүкийн магнайн ангитай тулалдаж эхэлсэн ч монгол цэргийн уламжлалт тактик болох өдөөх аргыг Байжу ноён хэрэглэн тулгаралтын дараа зугтааж буй дүр үзүүлэн гэдрэг ухарчээ. Энэ байдалд урамшсан Сельжүкийн султаны их цэрэг монгол цэргийг гэзэг даран нэхэж байхад II Гиас аддин Кеихосров султан, монгол цэргүүд ялагдсан гэдэгт итгэн Көседаг уулын бэлд байх аяны асартаа ялалтын баяраа тэмдэглэн найр үүсгэжээ. Гэвч 20-оод км үргэлжилсэн Көседаг

¹ <https://www.dailymotion.com/video/x6orww0>, 2018.07.15

уулын нарийн хөндийгөөр 80 мянган цэрэг байлдааны журмаар гарах нь хэцүү тул эмх цэгцээ алдан цуварч эхлэв. Ингэснээр тулалдааны санаачилга монголчуудын гарт шилжиж, монгол цэргүүд давшин орсонд Сельжүкийн цэргүүд ухарч эгнээ жагсаал нь бүрэн эвдэрч нарийн хөндийд багтаж ядсан цэргүүд ойр хавийн ууланд таран зугтсанаар султан ч сандран аяны цацар хийгээд дэргэдээ авч явсан үлэмж их хөрөнгө хогшлоо хаян умард зүгт орших Токат хотын зүг дутаажээ. Тулалдаанд ялагдсан II Гиас аддин Кеихосров султан монголын Алтан Ордны улсын Бат ханд мэргэн сайд Шамс аддин Исфахан-и, Амасиа хотын шүүгч Фахр аддин, хэлмэрч Маждаддин Мухаммед нарыг элчээр томилон дагаар орох хүсэлтээ уламжилснаар Көседаг уулын тулалдааны үр дүнд Анатолийн хувь заяаг Алтан Ордны улсаас шийдэж байх тогтолцоо бий болжээ (Анхбаяр, Батхишиг 2014, 54). Көседаг уулын тулалдааны дараа Байжу ноён Анатолийг орхиж Азербайжан руу буцсанаар 10 гаруй жил тухайн бүс нутагт монголчуудын нөлөө төдийлөн тусаагүй бөгөөд бүс нутгийг захирах эрхийг Сельжүкийн ноёд мэдэж монголчуудад татвар төлж байв. 1256 онд Байжу ноён Анатолид эргэн ирж Коньяа хот хүрэхэд Сельжүкийн зарим ноёд эсэргүүцэж тулалдсан ч амжилт олоогүй нь эргэлзээгүй юм (Kemal Ramazan Naykiran 2015, 44). Их Монгол улсын төрийн толгойд 1251 онд Мөнх хаан (1251-1259) гарч ирснээр төвлөрүүлэн захирах бодлогыг идэвхтэй явуулж 1253 онд Хүлэгүг өрнө зүгт илгээжээ. Хүлэгү хан 1254 онд Цагадайн улсын Алмалиг хотод хүрэхэд Ургуна хатан их ордод тосон төр ёсны хүндэтгэл үзүүлж (Мөнхтулга, Анхбаяр 2019, 31) Ираны зүг мордуулсан байдаг. Ингээд 1256 оны 01-р сарын 2-нд Амударьяа мөрнийг гатлан Иранд хүрчээ. Энэ үед Их Монгол улсын Ойрхи дорнод, Иранд эзэлсэн газруудыг захирах гэж ирсэн монгол цэргийн түмтийн ноён Аргун ага бараа бологчдын хамт ирж бараалхан өөрийн хүү болон Ата малик Жувейниг Хүлэгү хааны албат болгон өгөөд (Özkan Dayı 2020, 78) өөрөө Мөнх хаанд бараалхахаар оджээ. Энэ үеэс монгол хаадын төрийн бодлого, аян дайны тухай дэлгэрэнгүй бичсэн 3 ботиос бүрдсэн, бусад эх сурвалжид байхгүй зүйлсийг багтаасан сурвалж бичиг болох “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” буюу “Тарих-и Жахангушей” (перс: *تاریخ جهانگشا*) хэмээх алдарт сурвалжийн зохиогч Хүлэгү ханы албат болж хожим нь Абага, Тэгүдэр, Аргун нарт зүтгэж байжээ. Ил хаант улс нь өнөөгийн Ираны хойд хэсэгт Марага (1256-1265), Тебриз (1265-1306), Султанье (1306-1335) хотод тус тус нийслэллэж эдгээр хотод орд харш, сүм дуган зэрэг уран барилга байгууламжийг барьж байв. Ингэснээр Анатолийн бүс нутаг ч Ил хаант улсын харьяанд орж Эрзурум хот нь монголчууд төвлөн суусан хилийн нэгэн хот болжээ.

Торгоны зам Анатоли руу нэвтрэхдээ Арас голыг гаталдаг бөгөөд энэ гол нь урсгал ширүүн том гол тул тэмээн жин гарахад бэрхтэй аж. Газан ханы үед улс орон даяар ихээхэн бүтээн байгуулалт хийгдсэн байна. Ялангуяа торгоны замын дагуу дэн буудлууд барихдаа зам харгуйд ч ихээхэн анхаарсан юм. Эдгээрээс Ираны Марага хотын ойролцоох Мардак гол дээр баригдсан дөрвөн тулгууртай гүүр, Туркийн Эрзурум хотын дэргэд Арас мөрөн дээр баригдсан зургаан тулгуурт Чобандеде гүүрнүүд өнөө бидний үед уламжлагдан иржээ. Эдүгээ Турк улсад торгоны замын дэн буудлуудын зарим нь бараг бүтэн хэвээрээ хадгалагдан үлдсэн байдаг (Энхбат 2024, 227). Энэхүү гүүрийг 1295-1297 оны хооронд барьсан бөгөөд

энэ нь Анатоли дахь эртний гүүрнүүдийн нэгд тооцогддог аж. Гүүрийг бидний өвөг дээдэс “Торгоны зам” дагуух “Тебриз”-ээс Анатоли руу буюу өнөөдрийн Иранаас Турк рүү орох бүс, худалдааны их замыг дэмжих, хяналтдаа байлгах үүднээс “Арас” хэмээх мөрөн дээгүүр тавьж тухайн бүс нутагт суурьшлын тосгодыг байгуулсан нь өнөөг хүртэл оршсоор буй аж. Уг гүүр нь Ил хаант улсын бүтээн байгуулалтын нэг бөгөөд Газан хааны хувийн сан, “Чобан” ноёны хүч хөрөнгөөр бий болжээ. Уг гүүрийг удирдан бариулсан ноёны нэрээр “Чобандеде” (Зураг 2) гүүр хэмээн нэрийджээ. Гүүрийн урт 220 метр, Өргөн 8.5 метр юм (Улаанаа 2020).



Зураг 2. Чобандеде гүүр²

“Чобан” нь Ил хант улсын шадар сайд монгол ноён бөгөөд Деде нь түрэг хэлээр өвөө, өвөг гэсэн утгатай буюу өөрөөр хэлбэл, Чобан өвөөгийн гүүр гэсэн нэршилтэй дурсгал өнөөдөр ч энэ нэрээрээ буй.

Бидний өгүүлэн буй сэдэвт холбогдох дараагийн нэгэн дурсгал бол Хасан цайз (Зураг 3) юм. Энэ цайз нь Эрзурум хотоос зүүн тийш 57 км-ийн зайд Хасанкале тосгоны хойморт орших Хасан Баба уулын энгэрт оршино. 1313 онд Ил хан Абу Сайд өөрийн шадар, Хар татар аймгийн Сутай ноёныг Ахлат мужийн амбан захирагчаар томилон явуулжээ. 1335 онд Абу Сайд хан таалал төгссөний дараахан Сутай ноёны хөвүүд Чобан ноёны талыг баримтлан Жалайруудтай тулалдаж эхэлсэн байна. Энэхүү тулалдааны явцад амжилт олсон Сутай ноёны ач хүү Хасан ахай ноён Эрзурум мужийн захирагчаар томилогдож, энэхүү цайзыг бариулжээ (Анхбаяр, Батхишиг 2014, 147). Энэ цайз болон Чобандеде гүүр хооронд 15 км зайтай юм.

² https://erzurumportali.com/shf/6427/Cobandede-Koprusu#google_vignette, 2025.05.23




Зураг 3. Хасан цайз

Одоо Эрзурум хотын төвд байрлах дурсгалуудын тухай өгүүлье.

Эрзурумын хос баганат сүм/Хатуниеэ болон Якутиеэ медресе. Ил хаант улсын үед Эрзурумд баригдсан Хос баганат сүм /Хатуниеэ медресе (1285-1290) (Зураг 4), Якутиеэ медресе (1310-1311) (Зураг 5)-г онцлон барилгуудын ач холбогдлыг авч үзэв. Хос баганат сүм/Хатуниеэ медресе нь Эрзурумын цайзын дотоодод Тебризийн хаалга, Якутиеэ медресе-тэй нэг байршилд Эрзинжан хаалганы нээгдэх хэсэгт баригдсан. Өөрөөр хэлбэл, медресе бүрийг хотын зүүн баруун талаас гарах, орох хаалгатай ойрхон барьж, барилгуудын харагдах байдалд барилгыг ашиглах болон үйлчлүүлэх хүмүүсийн санал санааг ч тусгажээ. Эрзурумын Хос баганат сүм/Хатуниеэ медресе-н барилгын бичээс тэмдэглэл олдоогүй учир байгуулсан түүх болон бариулагчийн тухай маргаан буй. Барилгын материал болон архитекторын онцлогоос харвал 1285-1290 онд хамаарна. Хэд хэдэн судлаач Ил хаант улсын захирагч Гайхату Ринчендорж ханы (1291-1295) эхнэр Падишах хатан бариулсан хэмээх санал дэвшүүлдэг (Firdevs Özen 2016, 274). Үнэхээр ч Гайхату Ринчендорж ханы 4-р хатан болох Кирман мужийн захирагч Кутбаддины гүнж Худавенди Падишах энд амьдарч Мевланагийн сургаалыг сонирхон судалж байжээ. Медресе-г барьсан он цаг болон сан (Bani) ивээн тэтгэгчийн тухайд авч үзсэн өгүүлэлдээ Гүрбүз (Gürbüz) барилгыг II. Гияаседдин Кээхүсрев (Gıyaseddin Keyhüsrev)-ийн эхнэр Гүржү (Gürcü) хатнаас төрсөн охин Хунди (Hundi) хатны хойд эцэг Муйнеддин Сүлейман Ферване (Muinedddin Süleyman Pervane) 1266-1277 онд бариулсан байж магадгүй гэж үзжээ (Osman Gürbüz 2004, 45). Хос баганат сүм/Хатуниеэ медресе-н урд хойд тал нь жигд биш ч тэгш өнцөгт хэлбэртэй дээвэр

нь задгай, задгай талбайн дөрвөн талаас асартай, дөрвөн саравчтай хоёр давхар медресе юм. Барилгын дотор талын хананы дагуу хажуу/зүүн болон баруун асруудад залгаа дөрөв дөрвөөр найман сурагч байрлах нэгэн адил тасалгаануудыг хийжээ. Дотор талын хойд жигүүрт босоо тэнхлэгт байрлах орох хэсгийн зэрэгцээ асарт хоёр, хоёр дөрвөн өрөө байрлана. Орох хэсгийн баруун асарт зэрэгцээ дөрвөлжин хэлбэртэй орой хэсэг нь гурвалжилж нумарсан үетэйгээр хийгдсэн бөмбөгөр дээвэртэй сүм, илүү өргөн уужим болох үндсэн буюу өмнө асрын урд талд хоёр давхар бунхан байрлана. Медресе-н үүдийг нуман хэлбэртэй үйлдэж хоёр хажууг нь навчин хээгээр, дээд хэсгийг нь торон хээгээр чимэглэж үүдний гаднах хоёр талын хананд вааран дундаас ургасан амьдралын мод, хоёр толгойт бүргэд дүрсэлжээ. Энэхүү медресе нь Анатолийн хамгийн том медресед тооцогддог билээ.



Зураг 4. Хос баганат сүм

Якутиез медресе-н барилгын бичээс, жас сангийн тэмдэглэлээр 1310-1311 онд Жемалэттин Якут Эл-Газани-ийн зарлигаар Ил хаант улсын хаан Өлзийт (1304-1316)-ийн үед бариулжээ. Титэм хаалганы бичээст медресе-н тухай биш оршуулга гэсэн үгээр бунхны тухай өгүүлсэн байна. Бичээст “Энэхүү оршуулгыг үйлдсэн хижрийн 710 нийтийн тооллын 1310 он хаан Өлзийтийн засаглах цагт хаан Газан хатан Булганы тусламжтайгаар... Жемалэддин Хожя Якут тушаасан” хэмээн бичсэн байна (Rahmi Hüseyin Ünal 1992, 11). Үүнийг тодруулбал, Якутиез медресе-н гол хаалган дээрх араб хэлээрх бичиг нь “Энэхүү медресег Өлзийт султаны хаанчлалын өдрүүдэд (Аллах төрийг нь мөнхжүүлэх болтугай) султан Газан ба Булган хатны (Аллах сүнсийг нь амаржуулах болтугай) өндөр дээд буянд түшиглэн Жемалэддин Хожя Якут-и Газан-и зарлигдан бариулбай” гэжээ. Булган хатан бол Газан ханы дэд хатан бөгөөд Ил хаант улсын төрийн нэрт зүтгэлтэн Ойрадын Аргун Ахай ноёны ач охин юм. Газан хан бүх хатан дотроосоо хамгийн их хайртай нь Булган хатан хэмээх бөгөөд Булган хатан төрөлхийн гоо үзэсгэлэнтэйгээс гадна оюуны гоо үзэсгэлэн төгс юм хэмээн тайлбарлажээ. Булган

хатан маш шударгын дээр өрөвч нинжин сэтгэлтэй байсан аж. Амьдралынхаа туршид шоргоолжинд ч хор хүргэлгүй амьдарсан нэгэн бөгөөд эрдэмтэн мэргэд, лам нарт тусгайлан ивээлээ үзүүлдэг байв.



Зураг 5. Якутиев медресе

Тэрээр 1310 оны 1 дүгээр сарын 5-нд Багдад хотын Багдад ордонд таалал төгсжээ. Шарилыг нь Тебриз хотноо авчирч Газан хааны бунханд хамтад нь оршуулжээ. Энэ үер Өлзийгөө гүнж Амударьяа мөрний ус мэт нулимс асгаруулан гашуудан хайлахуйд Өлзийт хан түүнийг аргадан тайвшруулахыг хичээсэн авч тусыг эс олов. Өлзийгөө гүнж “Би золгүй заяа, зовлонт амьдралдаа гашууднам.

Шударга журамт агуу их Газан хан эцгээ би хүүхэд ахуйдаа алдав. Түүний дараа нүд сэтгэлийг минь гэрэлтүүлэгч Булган хатан эх минь таалал боллоо. Ганц утга учир минь тэр байжээ. Гэтэл намайг ганцааранг минь орхин одов, яахан эс уйлах билээ би” хэмээсэн гэдэг (Мөнхтулга, Анхбаяр 2019, 279). Энэ нь Якутиез медресег барих болсон нэгэн шалтгаан байж болох юм. Энэхүү медресе-н үйл ажиллагааг эдийн засгийн талаас хангах зорилгоор Эрзурум хотын ойролцоох зарим тосгодыг жас болгон хандивласан тухай мөн бичээст дурджээ. Үүнээс гадна медресе-н сүмийн чимэглэлийн урд асарт зүүн болон баруун ханануудын дээд хэсгээр хоёр мөр бүхий жас-сангийн хэсэг чухаг мэдээлэл бүхий жас-сангийн бичээс (чулуун бичээс) байна. Жас-сангийн бичээст хөрөнгө оруулагч Жемалэддин Хожа Якутийн нэр, Аугуу хаан Өлзийтийн ноёрхлын цаг үед, элбэрэлт хаан Газан болон Хорасаны Булган хатны энэрэл буянд энэхүү барилгыг барихыг зарлигдсаныг бичжээ. Медресе нь зүүн баруун тал тэгш өнцөгт хэлбэртэй, битүү дээвэртэй, дээврийн дөрвөн тулгуурт хөндлөн хонгилон холбоосийн сул зайг дүүргэсэн гоёмсог сийлбэрээр бүрхэгдсэн, гурван асартай ганц давхар барилга юм (Kuran 1969, 124). Барилгын нүүрэн талын хос баганат гадна хаалга болон баганын их биед шаазан түлхүү ашигласан нь Анатолид бус Тебриз дахь Ил хаант улсын барилгуудад голлон тааралдана. Медресе-н ханыг титэм адил сүрлэг болгох багануудад оюу болон ил далд тоосгыг хэрээслэн чимэглэх аргыг хэрэглэжээ. Ил хаант улсын үед Анатолид баригдсан медресенүүдийн ихэнх нь хийц төрлөөрөө ялгардаг.

Хоёр барилгын титэм хаалганд азийн соёлд хамаарна хэмээн үзэж буй сийлбэр гоёл чимэглэл байрлана. Эрзурумын хос баганат сүмийн хойд хананы дагуу титмэн хаалганы хос баганын тавцан дахь гурван төвгөр хэв бүхий гурван тал нь хурц ирмэгээр эмжин хүрээлсэн хотгор хэсэгт их бие нь зөрж байрласан хоёр луун дүрст сийлбэрийн хооронд салаалсан дал модыг хээлж мөчрүүдэд нь жимс болон шувууг дүрсэлж амьдралын модны дээд хэсэгт хоёр толгойт бүргэдийн хээн сийлбэртэйгээр зохиомжилсон байна (Blessing 2020, 167).

Эрзурум Якутиез медресе-н баруун хананы дунд хэсэг дэх титэм хаалганы хажуу нүүрэнд доод тал нь тэгш өнцөгт хүрээтэй, товойлгон үелж хээлсэн хэлбэртэй товгор эмжээрт хотгорын гадаргууд бумбаас үндэслэсэн амьдралын мод, модны их бие рүү буюу амьдралын мод руу харсан хоёр арслангийн сийлбэр, модны оройд хос толгойт бүргэд, түүний дээр гадаргууг нь чимэглэсэн дугариг хүрээтэй тэмдэг сийлсэн байна. Үүнтэй холбоотойгоор судлаачдаас Мүлаим (Mülayim) “Ил хаант улсын үеийн Анатолийн барималд азийн уламжлал сэтгэлгээ” сэдэвт өгүүлэлдээ энэ үед гоёмсог барилгуудад азийн уламжлал сэтгэлгээт дүрслэлийг тусгасан байгааг онцлоод, “...Ил хаант улсын үед хамаарах селчукийн уран барилгын хананууд дахь анхаарал татах хэмжээний зурсан зарим тэмдгийн хэсэгт нэгэн сүлд тэмдэглэгээг үйлдэж дүрсэлсэн... Өмнө өгүүлснээр бүх зохиомж нь Ил хаадын захиргаан дахь 40 жилийн дотор бий болсон байна. Ийм байдлаар шинжлэх аваас өнгөрсөнд, цаашид ч юун сүлд юун бэлгэ тэмдэг...” хэмээн тайлбарлаж жишээ болгон тохиолдож буй гоёл чимэглэлийн утга санаа зохиомжийг сүлд бэлгэ тэмдгийн шинжтэй болохыг тэмдэглэсэн байна (Selçuk Mülayim 2016, 177). Ялангуяа баримлууд болон амьдралын модны дүрслэлүүдийг

шигтгэн сийлсэн медресенүүдийн гоёл чимэглэл нь тэгш дөрвөлжин жааз, шовх бүслүүрт хүрээ, амьдралын модны гол хэсгээр шаталсан дүрслэлүүдийн эгнээ дунд мэдрэмж болон соёлын ой санамжийг харуулсан сүлд тэмдэг шүтээний уламжлал сэтгэлгээг тусган илэрхийлжээ. Үүний шалтгааныг дараах байдлаар тайлбарлаж болмоор санагдана. Газан хан лалын шашинд орсныхоо дараа 1302 онд Багдад руу явах замдаа лалын ёсоор мөргөл үйлдэж, Куран судрын номлол уншжээ. Үүнийг харсан Болд Чинсан тэнд байсан нэгэн модонд хадаг зүүж бөөгийн ёслол үйлдэхийг цэргүүддээ тушаав. Тэгээд Газан ханд хандаж “Таны элэнц өвөг Хотул хаан цөөн хэдэн аймгийг л захирдаг байсан. Иймд баатар хүний тухай ярихдаа заавал Хотул хааныг дурддаг. Түүний тухай олон шүлэг бичигдсэн. Түүний дуу долоон уулын цаанаас аймшигтайяа сонсогддог байсан. Хотул хаан нэг өдөр мэргэдтэй дайтахаар мордох замдаа тааралдсан сүрлэг саглагар модонд мөргөж, тулаанд ялахад туслахыг хүсжээ. Тэгээд хэрвээ “Би ялах юм бол энэ модыг мөргөлийн газар болгож, олон өнгийн даавуугаар гоёж чимнэ” гэж айлджээ. Мөнх тэнгэр түүнийг ивээж ялалт хайрласан аж. Хотул хан буцахдаа мөнөөх модон дээр ирж хэлснээ ёсоор болгов. Тэгээд цэргүүдтэйгээ уг модыг тойрон бүжиглэсэн бөгөөд модны орчим газар метр шахам хонхойсон гэдэг” хэмээн ярьжээ (Төмөртоогоо, Энхбат 2018, 62). Газан хан энэ түүхийг туйлын ихээр сонирхон таалж, Болд Чинсанд хандан “Хэрвээ бидний өвөг дээдэст маань ийм чин хүсэл, шударга үнэнч зан чанар байгаагүй бол тэднийг дэлхийн хаадын удирдагч болгохгүй байсан бөгөөд тэдний ургийг өндөр дээд сэнтийд залахгүй байх байсан” гэж хэлээд нүүдлийн цуваагаа хөдөлж бай гэж тушаажээ. Тэгээд Газан хан хадаг зүүсэн модонд нэг цагийн турш мөргөж, дараа нь цуваагаа нэхэж очсон гэдэг (Анхбаяр, Батхишиг 2016, 186). Энэ мэт баримтаас харахад, өнөө хэр буриадуудад уламжлагдсан мод чимэглэх эртний бөөгийн зан үйлийн нэг илрэл нь тэртээ XIII зуунд Ил хаадын уран барилгын чимэглэл болон дүрслэгдэж, амь мод гэсэн ойлголтоор үлдсэн байхыг үгүйсгэх аргагүй юм. Иран, Анатолийн нутгаар элбэг тохиолдох бөмбөгөр оройт байгууламжууд нь Ил хант улсын үеийн уран барилгаас үүдэлтэй бөгөөд төв азийн нүүдэлчдийн гэр байгууламжаас санаа авсан хэмээн судлаачид үздэг (Arseven 1956, 42). Якутиез медресе-н орой нь гадна талаасаа бөмбөгөр харагдахгүй ч дотор талаас нь харвал орой хэсгийг нь монгол гэрийн тооно адил, нарны гэрэл сүмийн дотор талыг бүрэн гэрэлтүүлэх боломжтойгоор урлажээ. Уг медресе-н бичээс болон 4 давхар хээ угалзаараа Анатолийн түүхэн дэх дундад зууны хамгийн үзэсгэлэнт уран барилгын нэгэнд тооцогддог юм. Эрзурумын түүхэн өв болж буй медресе уран барилга түүний зүйл, гоёл чимэглэлүүд дэх (цилиндрэн бөмбөгөр хүрдэн, конус хэлбэрийн шовх оройт, цилиндрэн их биет багана, титмэн хаалгууд ази соёлын холбоотой баримал чимэглэлүүд) хэл, оюун санааны дундын нийтлэг сонголт болох нь ойлгомжтой юм. Медресенүүдийг харахад өөр хоорондоо ойрхон бөгөөд аль алианаа харж байхаар төлөвлөсөн байршил нь дээрх санааг оновчтой гэж дүгнэхэд нөлөөлж болох юм.

Ил хаант улсын үед буюу 1290-1314 оны хооронд ойролцоогоор 30 жилийн хугацаанд Эрзурум хотод гурван Медресе баригдсанаар эрдэмтэн мэргэд, гүн ухаантнууд болон оюутан суралцагсад ирэх болсон ба хотод боловсрол, сургалтын үйл ажиллагаанаас үүдэлтэй нийгмийн орчин бүрэлдэн бий болсныг

харуулж байна. Энэ үед Эрзурум дээд боловсролын түвшний “Их сургуулиудын хот” хэмээгдэн алдаршжээ. Эрзурумын бэлэг тэмдэг болсон Ил хаант улсын үед баригдсан Хос баганат сүм/Хатуниез, Якутиез медресе нь өнөөдөр музейн зориулалтаар ашиглагдаж байна. Якутиез медресег 1994 оны 10 дугаар сарын 29-нд Турк-Исламын дурсгал, угсаатны зүйн музей болгожээ (*Erzurum* 2012, 347). Музейн үзмэрийн дотор монголын Ил хаант улсын үеийн зоосны цуглуулгад уйгуржин монгол бичигтэй зооснууд ч байна. Эрзурум хот дахь Ил хаант улсын соёлын дурсгалд хамаатуулж үзэхгүй байхын аргагүй бас нэгэн дурсгал 2019 онд Эрзурум хотоос олдсон нь монголчууд хэрэм цайзыг эзлэхдээ ашиглаж байсан зэвсэг болох Чөдөр оньс (Зураг 6) юм. Энэ нь ойролцоогоор 2 тонн жинтэй бөгөөд өнөөдөр Эрзурум хотын музейд байрлуулсан уг зэвсгийг Ататуркийн их сургуульд судалж байна.



Зураг 6. Эрзурумаас олдсон Чөдөр оньс

Дүгнэлт

Эцэст нь тэмдэглэхэд, монголчуудын байлдан дагууллын үр дүнд Ил хаант улсын үед Эрзурум хотын бэлэг тэмдэг болсон Хос баганат сүм/Хатуниез, Якутиез медресе баригдаж, Османы улсаас өнөөгийн Турк улс хүртэлх урт хугацааг дамжин оршиж сүр жавхлантайгаар сүндэрлэсээр байна. Үүнээс гадна Чобандеде гүүр, Хасан цайз, Чөдөр оньс гээд бидний өвөг дээдсийн үүх түүхийг харуулсан дурсгал, дурсгалт газрууд нь тухайн бүс нутгийн нэрийн хуудас болж жуулчид хол ойрын хүмүүсийн хөлд дарагдсаар байна. Энэ нь зарим түүх бичлэгт болон барууны зарим судлаачдын өгүүлдгээр, монголчууд нь аян дайныхаа явцад хот балгадыг эвдэн сүйтгэж, хүн ардыг хөнөөн хядаж байсан гэсэн үзлийг няцаах баримтуудын нэг юм. Өнөөдөр монголчууд Турк рүү ихээр аялах болсон хэдий ч зөвхөн Истанбул болон тухайн бүс орчмын аялал жуулчлалын газруудыг үзээд өнгөрдөг нь нэгд, мэдээлэл хомс, хоёрд, тухайн бүс нутаг нь Истанбулаас алс зэргээс шалтгаалж буй бололтой. Бид юун түрүүнд энэ талын судалгааг өргөжүүлж, нийтэд

сонирхолтойгоор танилцуулж, өвөг дээдсийнхээ үүх түүхээр бахархах сэтгэлгээг төлөвшүүлж, тухайн газруудаар аялах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй юм.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Анхбаяр, Д., Батхишиг, Б. 2014. *Монголын Ил Хаант улсын түүх соёлтой холбоотой Турк дахь зарим газар, дурсгалт зүйлс*. Анкара.

Анхбаяр, Д., Батхишиг, Б. 2016. *Ил хаадын замаар*. Улаанбаатар: ШУА.

Төмөртоогоо, Д., Энхбат, А. 2018. *Эл хаант улсын соёл бичгийн дурсгалууд*. Улаанбаатар: Жиком Пресс.

Мөнхтулга, Р., Анхбаяр, Д. 2019. *Монголын Эзэнт гүрний түүх “Цагадайн улс”*. Улаанбаатар: Steppe Publishing.

Энхбат, А. 2024. *Исламын ертөнц ба монголчууд*. Улаанбаатар.

Гадаад хэлээр:

Arseven. 1956. *Türk Sanat Tarihi*. Istanbul: C.I.

Blessing. 2020. *Moğol Fhethinden Sonra Anadolu'nun Yeniden İnşası*. Ankara: KOÇ ÜNİVERSİTESİ YAYINLARI.

Erzurum. 2012. Compiled by Metin Eriş. İstanbul: Kültür konseyi derneği.

Firdevs Özen. 2016. “İlhanlılar Devrinde Erzurum.” *Ankara Üniversitesi Dil ve Tarihi-Coğrafya Fakültesi* 56, no. 2 (6): 274.

Jean-Paul Roux. 2001. *Moğol İmparatorluğu Tarihi (Histoire de L'Empire Mongol, 1993)*. Istanbul: Kabalıcı Yayınevi.

Kemal Ramazan Haykıran. 2015. *Moğollar ve Mevlana*. Istanbul: Sentez.

Kuran. 1969. *Anadolu Medreseleri I*. Анкара: TÜRK TARİH UKRUMU.

Osman Gürbüz. 2004. “Erzurum Çifte Minareli Medrese'nin Yapım Tarihi ve Banisi Hakkında Yeni Bir Yaklaşım.” *Atatürk Üniversitesi Türkiyat araştırmaları Dergisi* 25, no. 2 (12): 45.

Özkan Dayı. 2020. *Moğolları Teşkilat ve İdarı Tarihi “İran Moğolları 1220-1295”*. Ankara: Altın Ordu.

Rahmi Hüseyin Ünal. 1992. *Erzurum Yakutiye Medresesi*. Ankara: Kültür Bakanlığı Yayınları.

Selçuk Mülayim. 2016. “İlhanlı Döneminde Anadolu Plastiğinde Asya Çağrışımları.” *Selçuklu Medeniyeti Araştırmaları Dergisi* 1, no. 1 (12): 277.